

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 09-р сарын 07-ний өдөр

№ А/15-Т

Улаанбаатар хот

Эчнээ санал хураалт явуулах тухай

Компанийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 73 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын Гуравдугаар бүлгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын А/02 тоот шийдвэрээр батлагдсан Компанийн 85%-ийг эзэмшдэг “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-аас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар авсан зээл болон хуримтлагдсан хүүг хоёрдогч өглөгт хөрвүүлэх хэлцлийн бүтэц болон нөхцөлд Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөмжийн дагуу өөрчлөлт оруулсныг баталж Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалт явуулж шийдвэрлүүлэхээр тогтоосугай;
2. Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай;
3. Энэхүү тогтоолыг баталсан тухай мэдэгдлийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д үүрэг болгосугай;
4. Компанийн эчнээ санал хураалтын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, Компани болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор нийтэд мэдээллэж, зарын давталтыг 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээллэсүгэй;
5. Эчнээ санал хураалтыг 2021 оны 09 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 26-ны өдрийн 18:00 цаг хүртэл явуулсугай;
6. Эчнээ санал хураалтын “Санал авах хуудас”-ын загварыг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтаар, эчнээ санал хураалтын зарыг олон нийтэд хүргэх зарын загварыг Хоёрдугаар хавсралтаар, эчнээ санал хураалтаар шийдвэрлэхтэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай;
7. Дараах нэр бүхий хүмүүсийг эчнээ санал хураалт зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - 7.1. Эчнээ санал хураалт зохион байгуулах комиссын дарга:

Р. Мөнхтөр	Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн Дэд захирал
------------	--
 - 7.2. Эчнээ санал хураалт зохион байгуулах комиссын гишүүд:

А. Энэрэл	Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга
С. Тулга	СУХЗ-ын газрын захирал
Ө. Билгүүн	Ахлах маркетингийн менежер
З. Балжиржанцан	Ахлах санхүүгийн шинжээч
Б. Мөнх-Эрдэнэ	Оффис менежер

8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

8.1. Тооллогын комиссын дарга:

Ж. Азбаяр “Инвескор капитал ҮЦК” ХХК

8.2. Тооллогын комиссын гишүүд:

О. Тэргэл “Инвескор капитал ҮЦК” ХХК

Г. Лхагва-Очир Туслах дотоод аудитор

9. Эчнээ саналын хуудас, эчнээ санал хураалтаас гарах шийдвэрийн төсөл, танилцуулга болон холбогдох баримт бичгийг бэлдэн 2021 оны 09 дүгээр сарын 15-ны дотор хувьцаа эзэмшигчид үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д үүрэг болгосугай;

10. Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд эчнээ санал хураалтын саналын хуудас болон холбогдох баримт бичгийг 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж, Твин Тауэр-2-ын 13 давхарт болон хувьцаа эзэмшигчид үйлчилж буй брокер, дилерийн компаниудаар дамжуулан танилцуулсугай;

11. Хувьцаа эзэмшигчдээс эчнээ саналын хуудасыг 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 18:00 цаг хүртэл Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж, Твин Тауэр-2-ын 13 давхарт хүлээн авч, эчнээ санал хураалт явуулсугай;

12. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/, Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА





**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
САНАЛ АВАХ ХУУДАС
Хэлэлцэх асуудал № 1**

Хувьцаа эзэмшигчийн:

Овог: _____ Нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Бүртгэсэн Брокер, дилерийн компанийн нэр _____

Бүртгэсэн Брокерийн овог, нэр _____

Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтын саналыг 2021 оны 09 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 26-ны өдрийн 18:00 цаг хүртэл “Инвекор ББСБ” ХК-ийн Төв оффист буюу Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж, Твин Тауэр-2-ын 13 давхарт хүлээн авна.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	“Инвекор ББСБ” ХК-ийн зарим зээлийн эх үүсвэрийг хоёрдогч өглөг рүү хөрвүүлэх хэлцлийн бүтэц болон нөхцөлд өөрчлөлт оруулах			

Санал авах хуудсыг ашиглах санамж:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэн санал өгөх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн эчнээ санал хураалтыг хүлээн авах сүүлчийн өдөр хүчинтэй байна.
- Засварласан, балласан, залруулгатай, болон нэгээс олон санал өгсөн санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Санал авах хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурьдана уу.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ /гарын үсэг/
/тамга/

Брокерийн гарын үсэг _____ /гарын үсэг/
/тамга/

2021 оны ___-р сарын ___-ны өдөр



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ ЗАР**

Компанийн нэр:	Инвескор ББСБ ХК
Хурлын төрөл:	Эчнээ санал хураалт
Санал хураалт авах хугацаа:	2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрийн 18:00 цаг хүртэл
Бүртгэлийн өдөр:	2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр
Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал:	“Инвескор ББСБ” ХК-ийн зарим зээлийн эх үүсвэрийг хоёрдогч өглөг рүү хөрвүүлэх хэлцлийн бүтэц болон нөхцөлд өөрчлөлт оруулах.
Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:	Хувьцаа эзэмшигчид нь 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон Компанийн төв байранд ирж хурлын баримт бичигтэй танилцаж болно. Эчнээ хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:30-18:30 цагийн хооронд ажиллана.
Эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргасан этгээд, шийдвэрийн огноо, дугаар:	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/15-Т тоот тогтоол.
Эчнээ санал хураалт зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн:	Хурлын комиссын дарга: Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн Дэд захирал, Р. Мөнхтөр, munkhtur@invescore.mn , 99082981 Хурлын комиссын гишүүд: 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга А. Энэрэл, enerel@invescore.mn , 88103947 2. Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал С. Тулга, tulga.s@invescore.mn , 88062502 3. Санхүүгийн шинжээч З. Балжиржанцан, baljirjantsan@invescore.mn , 90049978 4. Маркетингийн менежер Ө. Билгүүн, bilguun@invescore.mn , 80006606 5. Оффис менежер Б. Мөнх-Эрдэнэ, munkherdene.b@invescore.mn



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ШИЙДВЭРЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн жагсаалт
1	“Инвескор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалт явуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/15-Т тоот тогтоол;
2	Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалт явуулах тухай зар;
3	Хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудас;
4	“Инвескор ББСБ” ХК-ийн 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан;
5	“Инвескор ББСБ” ХК-ийн зарим зээлийн эх үүсвэрийг хоёрдогч өглөг рүү хөрвүүлэх хэлцлийн бүтэц болон нөхцөлд өөрчлөлт оруулах санал;
6	Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтаас гарах шийдвэрийн төсөл;
